



**ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН  
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН  
ТУШААЛ**

2016 оны 10 сарын 24 өдөр

Дугаар а/36

Улаанбаатар хот

**Ажлын байран дахь хувцаслалтын  
журам батлах тухай**

ЭМС-ын 2014 оны 187 тоот тушаалын гуравдугаар хавсралт “Хувийн хамгаалах хувцас хэрэгсэл хэрэглэх заавар”, 2015 оны 189 тоот тушаалын 3.2 дахь “Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны ажлын байранд нийтлэг мөрдөх хувцаслалтын хэм хэмжээ” заалт, Удирдлагын зөвлөлийн 2016 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. ЦССҮТ-ийн ажиллагсдын ажлын байран дахь хувцаслалтын журмыг нэгдүгээр хавсралтаар, хувцаслалтыг үнэлэх үзүүлэлтийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Батлагдаж буй журмыг төвийн нийт ажилчдад танилцуулах сургалт зохион байгуулах, ажлын байранд мөрдөж хэвшүүлэхийг Халдвар судлаач эмч Ц.Саруулд үүрэг болгосугай.
3. Тушаалыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан улирлын үр дүнгийн урамшууллын үнэлгээний “Халдвар хамгааллын дэглэмийг мөрдөж байгаа байдал”-ыг 2016 оны 10-р сараас эхлэн Халдвар судлаач эмч /Ц.Саруул/-ээр үнэлдэг болгож өөрчилсүгэй.
4. Ажлын байран дахь хувцаслалтын журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Чанар, цусны сонор сэрэмжийн албаны дарга /Т.Алимаа/, Халдварын сэргийлэлт хяналтын баг, Өмч хамгаалах байнгын зөвлөл, алба, тасгийн эрхлэгч нарт тус тус даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ  Н.ЭРДЭНЭБАЯР



Tushaal.2016.doc

## ЦССҮТ-ийн ажиллагсдын ажлын байран дахь хувцаслалтын журам

### Нэг. Зорилго

Байгууллагын нийт ажиллагсад ажлын дүрэмт хувцсыг ажлын байран дээр тогтмол, зөв өмсөж хэвших хандлагыг төлөвшүүлэхэд энэхүү журмын зорилго оршино.

### Хоёр. Хэрэглэх хүрээ

Энэхүү журмыг Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн нийт эмч ажиллагсад дагаж мөрдөнө.

Нэр томьёог дараах утгаар ойлгоно.

- “**Ажлын хослол**” гэдэг нь ажилтан ажлын байран дээр үйлчилгээ үзүүлэх явцдаа өмсөх нэгдсэн журмаар олгосон өмд цамцны хослол
- “**Ажлын хувцас**” гэдэг нь ажилтан ажлын байран дээр бус гадуур үйлчилгээ үзүүлэх явцдаа өмсөх байгууллагын лого бүхий нэгдсэн журмаар олгосон цамц, хүрэм зэрэг болно.
- “**Дүрэмт хувцас**” гэдэг нь ажилтан ажлын байран дээр үйлчилгээ үзүүлэх явцдаа өмсөх нэгдсэн журмаар олгосон лого бүхий халад, ажлын хослол, ажлын хувцас зэрэг болно.
- “**Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл**” гэдэгт ажилтан лаборатори болон үйлдвэрлэлийн ажлын байран дээр химийн бодис найруулах, боксонд ажиллах, цус цусан бүтээгдэхүүн цуглуулах, шинжлэх, үйлдвэрлэх үед дүрэмт хувцсан дээр нэмэлтээр өмсөх хамгаалалтын тусгай хэрэгслүүд орно. Үүнд малгай, маск, бээлий, буруу энгэртэй халад, хормогч, нүдний шил, нүүрний халхавч, усны гутал зэрэг болно.

### Гурав. Эмнэлгийн ажилтны дүрэмт хувцсанд тавигдах шаардлага

- 3.1. Дүрэмт хувцас, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл нь ЭМС-ын 2014 оны 187 тоот тушаалын 3-р хавсралт “Хувийн хамгаалах хувцас хэрэгсэл хэрэглэх заавар”, 2015 оны 189 тоот тушаалын 3.2 дахь “Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны ажлын байранд нийтлэг мөрдөх хувцаслалтын хэм хэмжээ” заалтыг тус тус хангасан байна.
- 3.2. Ажлын үед шаардлагатай зүйлсийг хийх халаастай, бүрдэл хэсгүүд нь ажилтанд саад болохгүй байх.
- 3.3. Хувцасны загвар нь хөдөлмөрийн нөхцөл, биеийн хөдөлгөөний онцлогт тохирсон суух болон бөхийх үед хөдөлгөөнд саад болохооргүй байна. Биед дээд зэргээр таардаг байх.
- 3.4. Төмөр буюу металл гадаргуутай хүрэлцэх үед дүрэмт хувцас нь цахилгаанжихгүй, ажилтны биед харшлахгүй байна.

3.5. Ажлын байрны онцлог, шаардлагаас хамаарч хөдөлмөр хамгааллын хэрэгслийг тухайн ажлын байран дээр нэмэлтээр хэрэглэх ба гүйцэтгэж буй ажиллагааг дуусгаад тайлна.

#### Дөрөв. Дүрэмт хувцас өмсөх ангилал

Ажлын байр, хөдөлмөрийн нөхцлөөс хамааруулж ажлын дүрэмт хувцсаар хангагдах ажилтнуудыг хоёр түвшинд ангилна.

1-р хүснэгт

Д/д	Түвшин	Эрсдэл	Албан тушаалын нэр	Өмсөх дүрэмт хувцас
1	Ажлын дүрэмт хувцсаар хангах-I түвшин	Эрсдэл багатай бүлэг	Захиргаа, удирдлага, санхүүгийн болон эмнэлгийн бус мэргэжилтэй бусад ажиллагсад	Эмч халад Лого Энгэрийн тэмдэг
			Инженер, техникийн ажилчид	Ажлын хослол Лого
			Хөтөч	Дүрэмт хувцас
			Жолооч, туслах ажилтан	Ажлын хувцас Лого
2	Ажлын дүрэмт хувцсаар хангах-II түвшин	Эрсдэл бүхий бүлэг	Эмч нар	Эмч халад Ажлын хослол Лого Энгэрийн тэмдэг
			Бага эмч, лаборант, сувилагч	Сувилагч халад Ажлын хослол Лого Энгэрийн тэмдэг
			Тогооч, туслах тогооч, ариутгагч, хог хаягдлын ажилтан, үйлчилгээний ажилчид.	Ажлын хослол Лого Энгэрийн тэмдэг

#### Тав. Ажлын байранд мөрдөх хувцаслалтын хэм хэмжээ

- 5.1. Ажилтан нь ажлын байран дээр төвөөс хангасан эмч халад, сувилагч халад, ажлын хослол өмсөнө. Халад өвдөгнөөс доош, энгэр нь хэт задгай биш байна. Ажлын хослол нь хэт богино биш, энгэр нь задгай биш байна. Инженер, техникийн ажилтан, туслах ажилтан, жолооч нь байгууллагаас хангасан ажлын хослол болон хувцсыг өмсөнө.
- 5.2. Ажлын байран дээр гадуур өмсдөг гутлыг солих ба ажлын шаахай нь цайвар өнгийн хөлд таарсан, эмэгтэй ажилчдын ажлын шаахай нь өндөр өсгийгүй байна.
- 5.3. Ажилтан нь албан тушаал, овог нэр бичсэн цээж зураг бүхий энгэрийн тэмдэг зүүнэ.
- 5.4. Үсийг ажилд саад болохооргүй хавчиж боосон байна.

- 5.5. Явуулын багаар цус цуглуулах үйл ажиллагаанд оролцож байгаа бүх ажиллагсад байгууллагаас хангасан гадуур хувцсыг өмсөнө.
- 5.6. Тогооч, туслах тогооч үсийг ил гаргахгүй малгай өмсөж, хормогч зүүнэ.
- 5.7. Хурц, содон үнэртэй үнэртэн түрхэхийг хориглоно.
- 5.8. Хэт урт ээмэг, том овор ихтэй, олон тооны бөгж, хүзүүний зүүлт, бугуйвч зэрэг гоёл чимэглэлийн содон зүйлсийг зүүхийг хориглоно.
- 5.9. Үсийг бүрэн хусах, тод гаж өнгөөр будахыг хориглоно.
- 5.10. Хумс хурууны өндөгнөөс бага зэрэг давсан байх ба тод өнгөөр будахыг хориглоно.
- 5.11. Лаборатори, үйлдвэрлэл, ариутгалын өрөөнүүдэд нэгдүгээр түвшний ажлын дүрэмт хувцастай ажилчид орохдоо тухайн бүсэд тохирох хөдөлмөр хамгааллын хэрэгслийг нэмэлтээр өмсөнө.

### **Зургаа. Дүрэмт хувцас ашиглалтын хугацаа**

- 6.1. Хөдөлмөрийн нөхцлөөс шалтгаалж ажлын дүрэмт хувцасны ашиглалт эдэлгээний хугацаа 2 хүртэл жил байна.
- 6.2. Жил бүр хяналт үнэлгээ хийж, дүгнэлт гарган шаардлага хангахгүй, эдэлгээний хугацаа дууссан, зардлаа нөхсөн дүрэмт хувцсыг актлан, хэрэглээнээс хасч, нөхөн хангалт хийнэ. Эдэлгээний хугацаа дууссан, хэрэглээнээс хасах дүрэмт хувцсыг Өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэрээр актална.
- 6.3. Ажлын дүрэмт хувцасны ашиглалт, эдэлгээний хугацаанд худалдан авсан үнэ, чанар хийц болон байгаль цаг уур, гэнэтийн хүндрэлтэй нөхцлөөс шалтгаалан нэмэлт өөрчлөлт оруулж болно. Өөрчлөлтийг тухайн үеийн үүссэн нөхцөл байдлыг дүгнэн байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөл тогтооно.
- 6.4. Актлагдсан дүрэмт хувцсыг нөхөн хангалт хийснээс хойш ажлын байран дээр өмсөж үйлчилгээ үзүүлэхийг хориглоно.
- 6.5. Ажлын дүрэмт хувцас нийлүүлэгч аж ахуй нэгж, үйлдвэрлэгч нь заасан хугацаанд уг журмын шаардлагад нийцсэн хувцсыг нийлүүлнэ.


### **Долоо. Дүрэмт хувцасны халдваргүйжүүлэлт, угаалга**

- 7.1. Халдварын сэргийлэлт хяналтын журмын 10 дахь "Угаалгын хэсгийн халдвар хамгаалал" заалтыг баримталж ажиллана.

### **Найм. Бусад**

- 8.1. Энэхүү журмын хэрэгжилтэнд байгууллагын Халдварын сэргийлэлт хяналтын баг, Өмч хамгаалах байнгын зөвлөл, албадын дарга, тасгийн эрхлэгч нар хяналт тавьж ажиллана.
- 8.2. Хувцаслалтын үнэлгээг сар бүр ХСХ-ын баг хийж дүгнэж ажиллана.
- 8.3. Журмын 5-р заалтыг 1 удаа зөрчвөл анхааруулах, 2 удаа зөрчвөл сануулах ба түүнээс дээш удаа зөрчвөл ажилтны үр дүнгийн урамшууллын "Халдвар хамгааллын дэглэм"-ийн оноог хасах хүртэлх арга хэмжээг авна.

ЦССҮТ-ийн ерөнхий захирлын 2016 оны  
10...дугаар сарын 24-ний өдрийн 436-тоот  
тушаалын хоёрдугаар хавсралт



**Хувцаслалтыг үнэлэх үзүүлэлт**

Хувцаслалтыг үнэлэх үзүүлэлт: 1-р түвшний ажилчид

№	Ажилтны овог нэр	Албан тушаал	Эмч халад	Лого	Энгэрийн тэмдэг	Ажлын шаахай
1.						
2.						

Хувцаслалтыг үнэлэх үзүүлэлт: 2-р түвшний ажилчид

Эмч нар

№	Ажилтны овог нэр	Албан тушаал	Эмч халад	Лого	Ажлын хослол	Энгэрийн тэмдэг	Ажлын шаахай
1.							
2.							

Тусгай мэргэжилтнүүд

№	Ажилтны овог нэр	Албан тушаал	Үсний хавчаар	Лого	Ажлын хослол	Энгэрийн тэмдэг	Ажлын шаахай
1.							
2.							

Үйлчлэгч нар

№	Ажилтны овог нэр	Албан тушаал	Лого	Ажлын хослол	Энгэрийн тэмдэг	Ажлын шаахай
1.						
2.						

Жолооч нар

№	Ажилтны овог нэр	Албан тушаал	Лого	Ажлын хувцас
1.				
2.				